“ИРГЭНИЙ НИСЭХИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ” ТӨХХК
АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЧАНАРЫН УДИРДЛАГЫН ГАЗАР

АЮУЛГҮЙ БАЙДЛЫН АНХААРУУЛГА МЭДЭЭЛЭЛ /SAFETY BULLETIN/

2025 оны 10 сарын 14-ны өдөр № 06

АНХААРУУЛГА ХҮРГҮҮЛЭХ ТУХАЙ

ШУВУУ, МАЛ, АМЬТНЫ АЮУЛААС СЭРГИЙЛЬЕ!!!

Монгол улсад шувууд өвлийн улиралд дулаан орогнох газар хайх, ялангуяа 1 сар, 9 сард мөргөлтийн тоо нэмэгдэх хандлагатай байна. Ихэнх зүйл шувуудын хувьд намрын нүүдэл 8-р сарын эхээс 10-р сарыг дуустал явагдана. Нисэх буудлын аэродромын хамгаалалтын хашаанд шувуу, мал, амьтан нэвтрэх, цуглахаас сэргийлж дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ үү. Үүнд:

1. Хамгаалалтын хашааны бүрэн бүтэн байдлыг 7 хоног бүр тогтмол шалгах;
2. Аюултай шувуу, мал, амьтан хашаанд нэвтрэх боломжтой эсэхийг тогтмол шалгаж, амьтан илэрсэн тохиолдолд шуурхай үргээх, зайлуулах, аюулыг АБЧУГ-т **/Утас: 88974030/** мэдээлэх;
3. Өвсний өндрийг бүс нутгийн онцлогт тохируулан тайрах, багасгах, сийрэгжүүлэх;
4. Мод, бутны мөчрийг тайрах, шувуу суух, үүрлэх боломжгүй болгох, шаардлагатай тохиолдолд зайчлах, байршлыг өөрчлөх;
5. Үргээлгийн тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны зааварчилгааг мөрдөн ажиллах;
6. Нисэх буудал орчмын хаягдсан барилга, байгууламжийн балгас, саравч, эвдэрхий хашаа зэрэг ашиглагддаггүй барилга байгууламжийг шувуу, мал, амьтан үүрлэх, орогнохоос сэргийлж нураах, эсвэл битүүмжлэх, тогтмол шалгах;
7. Ил задгай орхисон хог, хаягдал, хоолны үлдэгдэл, үхсэн амьтны сэг зэм зэргээс шалтгаалж элээ, хэрээ, тагтаа, тас цуглах аюултай тул яаралтай зайлуулах;
8. Аэродром орчимд үүссэн хог хаягдлыг битүү саванд хадгалах, зөөвөрлөж зайлуулах;

Утас: 88974030
sqmd@mcaa.gov.mn